

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2016-08-04/

Ажлын хэсгийн 41 дүгээр хуралдаан 2016 оны 8 дугаар сарын 4-ны өдрийн 10.00 цагт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн байрны хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Авлигатай тэмцэх газрын соёон гэгээрүүлэх, урьчилан сэргийлэх хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дуламсүрэн, Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, Ашигт малтмалын газрын ОУИТБС-ыг хариуцсан мэргэжилтэн Н.Оюунцэцэг, Гааль татварын ерөнхий газрын байцаагч Ч.Батцэнгэл, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Бороо гоулд ХХК-ийн ахлах нягтлан бодогч П.Болормаа, Петроматад ХХК-ийн мэргэжилтэн Б.Оюунчимэг, Оюутолгой ХХК-ийн мэргэжилтэн Б.Ренчинпагма, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмааг төлөөлж мэргэжилтэн Баттуяа, МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, МБОИЗ-ийн гишүүн Х.Алтанцацралт, Хариуцлагатай уул уурхай ТББ-ийн тэргүүн Л.Долгормаа, Ил тод сан ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнжав, Миний монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 51,5 хувьтай байв. Мөн хуралдаанд ЕСБХБ-ийн захирал П.Моффат, Адам Смит хүрээлэнгийн захирал Р.Пелл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэд захирал О.Батболд, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг болон Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Ш.Цолмон: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн 41 дүгээр хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Нямаа удирдах байсан боловч яаралтай ажил гарсан тул хурлаа эхэлж байхыг хүслээ. Ингээд та бүхний саналыг асууя, хурлаа эхлэх үү? Гишүүд дэмжсэнээр ажлын хэсэг хурал эхлэв.

Ш.Цолмон: Хурал эхлэхийн өмнө та бүхэнд ОУИТБС-ын 2015 оны тайлангийн талаар мэдээлэл өгье. Бид 2016 оны 6 сараас эхлэн тайлангаа авч эхэлсэн, одоогоор 600 гаруй компани тайлангаа өгөөд байна. Төрийн байгууллагаас нийтдээ 40 гаруй байгууллага тайлан өгөх ёстой, үүнээс Сангийн яам, БОАЖНХ-ийн яам, Хөдөлмөрийн яам, Баянзүрх дүүрэг, Налайх Багануур дүүрэг, Дундговь, Өвөрхангай зэрэг аймгууд тайлангаа гаргаагүй байна. Төрийн байгууллагын тайлангаар нийт 1900 орчим компаниас хүлээн авсан 1,59 их наяд төгрөгийн орлогын тайлан гаргаад байна. Үүний аудитын компани ажлаа эхэлсэн байгаа. Энэ жил Улаанбаатар аудит шалгарч, гэрээ байгуулаад ажиллаж байна.

Одоо хуралдаа оръё, хурлын хөтөлбөрийн дагуу танилцуулгыг ЕСБХБ-ийн захирал П.Моффат хийнэ.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд ЕСБХБ-аас үзүүлж буй дэмжлэг, орон нутагт хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийн ач холбогдол, зорилт

П.Моффат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, та бүхэнтэй дахин уулзах боломж олдсондоо баяртай байна. Өнөөдөр би Адам Смит байгууллагын төлөөлөгч Жонатон Пеллтэй ирээд байна. Бид ОУИТБС-ын ажлын албатай хамтран хэрэгжүүлэхээр нэгэн төсөл бэлдсэн байгаа, энэ нь ОУИТБС-ын үйл ажиллагаа, харилцаа холбооны үйл ажиллагааг орон нутагт илүү түгээх чиглэлтэй төсөл юм. 2010 оноос хойш ЕСБХБ нь ОУИТБС-тай хамтран ажиллаж байгаа, бидний дэмжлэг үзүүлж хэрэгжүүлж байгаа билээ. Энэ бол 3 дахь төсөл болно. ЕБСХБ зүгээс ил тод байдлын санаачилгын чиглэлээр хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байдаг. Олон нийтэд ОУИТБС-ыг хүргэх асуудал чухлаар тавигдаж байна. Уул уурхай буюу олборлох үйлдвэрлэлийн салбараас өгөөж их хүртэж байгаа, нөгөө талаар үүнтэй холбоотой зардал, сөрөг нөлөө гарч байгаа. Тухайлбал байгаль орчныг бохирдуулах, газраа ашиглуулах гээд орон нутгийн иргэд маань үндсэн сөрөг талыг үүрээд, уул уурхайгаас олж байгаа орлого нь төвлөрсөн үндэсний хэмжээнд очдог болохоор орон нутагт ил тод байдлын санаачилгыг хүргэх нь чухал болж байна. Орон нутгийн иргэдэд үнэн бодит мэдээллийг хүргэх нь чухал байгаа, ингэснээр уул уурхайтай холбоотой сөрөг талууд багасах боломж нь нээгдэнэ гэж үзэж байгаа. Ил тод байдлын санаачилгын хүрээнд тайлан гаргах үйл ажил хийгдэж байгаа, бид үүнийг дэмжиж байгаа. Тэгэхээр орон нутгийн иргэдэд тэдэнд хэрэгтэй, хамааралтай мэдээллийг хүргэх нь чухал гэж үзээд энэ чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сонирхолтой байгаа. Ил тод байдлын санаачилгын мэдээллийг орон нутагт хүргэх нь санаачилгыг орон нутагт тогтвортой байлгахад чухал нөлөөтэй гэж үзээд энэ талын дэмжлэг үзүүлж байгаа юм. Орон нутагт ил тод байдлын талаарх мэдээллийг тодорхой хугацаанд, зөв хүмүүст, зөв мессэжийг хүргэх шаардлагатай. Төслийн тухай Жонатон танилцуулна. Бидний зүгээс та бүхэнтэй цаашдаа хамтран ажиллахад бэлэн байх болно. Бидэнд төсөл хэрэгжүүлэх боломж, арга хэрэгслүүд байна, ажлын алба, ажлын хэсэг, цахим тайлан зэрэг арга хэрэгсэл, нөөц их байна гэж үзэж байна.

Ж.Пелл: Сайн байцгаана уу, миний бие хамгийн сүүлд ажлын хэсгийн хуралд оролцсоноос хойш нилээд хугацаа өнгөрсөн байна, гэхдээ би ОУИТБС-ын талаар өдөр болгон боддог байсныг хэлье.

Хэдийгээр би Монгол улсад байнга байгаагүй ч гэсэн манай төслүүд хэрэгжээд явж байсан. Цахим тайлангийн системийн мэдээллийг та бүхэн авч ашиглаж байгаа гэдэгт найдаж байна. Одоо хэрэгжүүлж байгаа ажлуудын хувьд цахим тайлангийн үйл ажиллагаа 12 сар хүртэл үргэлжилнэ. Мөн хэрэглэгчдэд сургалт хийх төлөвлөгөөтэй байгаа. Бид цахим тайлангийн үйл ажиллагаагаа дуусгаад, энэ төслийг эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа. Одоо төслийн талаарх товч мэдээллийг өгье. Та бүхэн ямар саналтай байна, санал бодлоо илэрхийлэх нь бидэнд илүү үр дүнтэй байх болно. ОУИТБС-ын орон нутаг дахь мэдээлэл харилцааны туршилтын төсөл гэж нэрлэж байгаа, туршилтын төслийг хэрэгжүүлснээр олон зүйлийг сурч мэднэ, цаашдаа хийх зүйлээ сайжруулах боломжтой гэж үзсэн. Төслийн зорилт нь чадавхи бэхжүүлэх юм, ил тод байдлын санаачилгын чиглэлээр бидний хийж байгаа ажил дууссан ч цаашдаа Монгол улсын хэмжээнд тогтвортой үргэлжлээд явах чадавхитай болох юм. Өмнөх хэрэгжүүлж байсан төслүүдээс ялгаатай нь орон нутагруу чиглэж, хэрэгжихээрээ онцлогтой. Энэ төслийг хэрэгжүүлэх нь миний хувьд ч хөдөө орон нутагт, бодит байдал дээрээ ямар байгааг харах нь сонирхолтой байгаа нөгөө талаар энэ төслийг хэрэгжүүлснээр ОУИТБС нь зөвхөн тайлан гаргадаг бүтэц биш тайлангаас гарч байгаа мэдээлэл нь орон нутагт хийгдэх хэлэлцүүлгийн суурь болж байгаа юм. Төслийн гүйцэтгэх ажлын даалгаврыг урьд нь тараасан байгаа, цаашдаа

хамгийн гол зорилт нь мэдээлэл харилцааны стратеги боловсруулах юм. Өмнө нь харилцаа холбооны стратеги боловсруулж гаргасан, энэ удаа орон нутагт хэрэгжүүлэх харилцаа холбооны стратегийг боловсруулах юм. Үүнийг хийхэд ажлын алба, ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллана. Бид танилцуулгад хамгийн чухал гэсэн цөөн хэдэн ажлыг гаргасан, энэ дээр та бүхний саналыг авах хүсэлтэй байгаа. ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх төсөл нь 12 сарын хугацаатай хэрэгжинэ. Орон нутгийн сонгууль, өвөл болохоор хөдөө орон нутагт ажиллахад хүндрэлтэй зэргийг тооцоод дээрх хугацаанд хийхээр төлөвлөсөн. Төслийн хүрээнд сонгох таван сумыг ямар шалгуураар сонгох талаар өнөөдөр ярилцах нь чухал байгаа. Шалгуурууд нь тодорхой болсны дараа хэлэлцүүлэг хийгээд сумдаа сонгох юм. Сумаа сонгосны дараа уг суманд ямар асуудал тулгарч байна, ямар үйл ажиллагаа явуулдаг талаар болон ОУИТБС-ын талаар тухайн сумын иргэдийн мэдлэгийн түвшин ямар байгаа зэрэг ойлголт авахын тулд суманд ажиллана. Үүн дээрээ үндэслээд сум болгонд тохирсон нийтлэг болон тухайн сумын онцлогыг харуулсан стратеги боловсруулна, сонгосон 5 суманд төсөл зэрэг эхлэхгүй, бидний төсөөлж байгаагаар эхлээд нэг суманд хэрэгжүүлээд дараагийн суманд хэрэгжүүлэхдээ алдаа оноогоо хараад, авсан сургамжиндаа үндэслээд засаад явах юм. Бид төслийн үр дүнд төлөвлөгөө, аргачлал боловсруулж гаргах, цахим тайланг хэлэлцүүлгийн флатформ болгож ажиллах, цахим тайлангийн мэдээллийг түлхүү ашиглах, орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулсан бусад байгууллага хүмүүсийн туршлага, сургамжид тулгуурлаж үйл ажиллагаагаа явуулах, Монгол улсад бүрдэж бий болсон мэргэжилтнүүдийн мэдлэгийг түлхүү ашиглах, тухайлбал орон нутагт харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани, ИНБ-уудыг түлхүү оролцуулах, тэднээр дамжуулан үйл ажиллагаа явуулах, төсөл хэрэгжээд дууслаа гэхэд тогтвортой үргэлжлэх байдлыг хангах гэсэн хандлагуудыг барьж ажиллана. Төслийн талаар болон сум сонгох шалгууруудыг бэлтгэн урьдчилан тараасан байгаа, үүнд та бүхний саналыг авах хүсэлтэй байна. Сумын хэмжээнд хамгийн чухал ямар төрлийн асуудал байгаа талаар та бүхнээс асуух шаардлага байгаа юм. /Танилцуулгыг хавсаргав/

Ш.Цолмон: Танилцуулгыг сонирхолтой байдлаар хийсэн Пелл, Моффат нарт баярлалаа. Төслийн талаарх мэдээллийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн хүргүүлж, санал авсан байгаа. ТАН эвслийн гишүүн Наранцэцэг, Баярсайхан, БОНХАЖЯ-ны Саран, Сэлэнгэ аймгийн дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга Мөнхбат нар саналаа ирүүлсэн байна. Мөн төлөөлөгчид өнгөрсөн 7 хоногт Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б. Нямаатай уулзаж, төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулж санал бодол солилцсон байгаа. Засгийн газрын талаас боломжийн хэрээр дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлсэн. Мөн ажлын хэсгийн зарим гишүүд, компанийн төлөөлөлтэй уулзаж, тэдний санал бодлыг нь тусгасны үндсэн дээр өнөөдрийн танилцуулгыг хийсэн. Одоо асуулт тавих, санал хэлэх гишүүд байвал нэрээ хэлээд асууна уу.

Н.Баярсайхан: Баярлалаа, ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд орон нутгийн түвшинд ажил хийж байгаад, хэрэгцээ байгааг шийдэх төсөл хэрэгжих болсон байна. Энэ хэрэгцээг бид ЕСБХБ түүний төлөөлөл энэ Полтой 2014 онд тодорхойлсон. Бүтэн 6 сар харилцан мэйл бичиж ажилласан, тэгээд сүүлийн жил гаран хугацаанд чимээгүй болсон, тэр төслийг одоо хэрэгжих гэж байна гэж би ойлгож байна. Тэр үеэс хойш нөхцөл байдал өөрчлөгдөж байна, хууль эрх зүйн орчин, улс төрийн нөхцөл байдлын хувьд, мөн санаачилгын хувьд ОУИТБС-ийн стандарт өөрчлөгдсөн. Монгол улсад санаачилгыг хэрэгжүүлээд 10 жил болж байна, энэ хугацаанд талууд дор бүрнээ тодорхой ахицуудыг гаргасан. “ОУИТБС орон нутгаас эхэлнэ” гэдэг хэлэлцүүлгийг ТАН эвсэл 2008 оноос хийж байсан, бид орон

нутагт талууд хэлэлцүүлэг хийх платформ болгох боломжтойг тодорхойлсон, бидэнд энэ талаар хийсэн ажил, бас сургамж туршлагауд бий. Бид аймаг, сумын түвшинд хийж байсан, Уул уурхайн яам сар бүр нээлттэй мэдээлэл өгдөг болсон нь төрийн байгууллагын хувьд ахиц гарсан. Мөн компаниуд тайлан гаргадаг, хэвлэж орон нутагт тараадаг зэрэг сайн зүйлүүд, дэвшил гарсан байна. Энэ нь бүгдээрээ тодорхой туршлага, сургамжуудыг хуримтлуулсан гэсэн үг юм. Тэгэхээр энэ сургамж туршлагаудыг үнэлэх хэрэгтэй байна, энэ үнэлгээг хийсэн үү? судалгааг төсөл эхлэхээс өмнө хийж үнэлэх хэрэгтэй байна. Татварын орчин, төсвийн бодлогод өөрчлөлт орсон, сумын түвшинд уул уурхайн орлого орохгүй байгаа, жилийн дараа тайлан гарч байгаа нь хэлэлцүүлгийн платформ болж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Иймээс өмнө хийсэн ажил, туршлагыг үнэлэх хэрэгтэй байна. Одоо суманд очоод ОУИТБС-ын талаар танин мэдэхүйн танилцуулга хийхэд сонирхолгүй байна, тайлангаар зөрүү гарч байна, үүний мөрөөр ямар арга хэмжээ авсан талаар, тайлан гаргаагүй компанитай ямар хариуцлага тооцдог вэ гэж л иргэд сонирхоно. Иймээс нөхцөл байдал, хэрэгцээгээ тодорхойлохын тулд үнэлгээ хийх хэрэгтэй байна, сум байх уу аймаг байх уу?, бид олон жил суманд ажиллаж ирлээ, аймаг дэмжихгүй бол сумын ажил явахгүй байна, иймээс үнэлгээ хэрэгтэй байна. Үндэсний харилцааны менежментийн төлөвлөгөө боловсруулж өгсөн, түүний хэрэгжилт ямар байна вэ? Урьд нь хийсэн ажлаа үнэлж байж цааш явах хэрэгтэй байна, бас нэг хэрэгждэггүй стратеги боловсруулвал яах вэ, суманд яаж хэрэгжүүлэх вэ?

Үндэсний олон төрийн бус байгууллагууд байна, энэ талаар ажилладаг ТАН эвсэл байхад хамтарч ажиллахгүй заавал яагаад гадаадын байгууллагыг сонгосон юм бэ? Иргэний нийгмийн байгууллагууд ямар оролцоотой байх юм бэ? Үүнийг тодруулмаар байна.

Л.Долгормаа: Төслийг дэмжиж байна, туршилтын төсөлд хамрагдах сумаа зөв сонгох хэрэгтэй, төсөв мөнгө нь хүрэлцээтэй байгаа бол холын уул уурхай хамрагдсан сумыг сонгох, юу хийхээ тогтох хэрэгтэй.

П.Моффат: Бид 2,3 жилийн өмнө орон нутагт хэрэгжүүлэх төслийн талаар санаа гаргаж байсан, тэр санаагаа цааш нь танилцуулахдаа энэ төсөл зайлшгүй хэрэгжих хэрэгцээ шаардлага байна гэдгээ итгүүлж чадаагүйгээс санхүүжүүлэх шийдвэр гараагүй. Бид тухайн үед яригдаж байсан зүйл дээр үндэслээд, хэрэгжүүлсэн 2 төслийн сургамж дээр үндэслэн нийлүүлж гаргаж ирсэн төсөл юм. Таны асуусан олон асуултанд хариулахын тулд бид энэ төслийг хэрэгжүүлэх шаардлага байгаа юм. Энэ төслийн хувьд та бүхний саналыг сонсож, төслийн үйл ажиллагаанд уялдуулахаар энэ арга хэмжээг зохиож байна. Бидний боловсруулсан төсөл дээр зарим үйл ажиллагаанууд тусгагдсан байгаа. Өмнө нь хийгдсэн ажил, туршлага дээр суурилад цааш явахаар төсөлд тусгагдсан байгаа. Санхүүжилт төсвийн хувьд хараахан эцэслээгүй байгаа, ямар хэрэгцээ байна, юу хийх шаардлагатай зэргээс үндэслээд төслийн санхүүжилт эцэслэгдэх юм. Хол ойроос шалтгаалан хол сумыг сонгох нь зардал ихтэй гэсэн үүднээс түүнийг сонгохгүй байх учиргүй. Шалгуур үзүүлэлтээс хамаарч сумаа сонгох юм. Ажлын удирдамж дээрээ үндэслээд төлөвлөгөө хийх байх.

Ж.Пелл: Зарим зүйлийг тайлбарлая. Төслийн хувьд яг юу хийх нь одоогоор тодорхой эцэслээгүй байгаа, төлөвлөгөө гаргах шатандаа байна. Монголын компани, оролцогч талууд болон ажлын хэсэгтэй аль болох хамтарч ажиллах зарчим барина. Одоо бид өмнө боловсруулсан харилцаа холбооны стратеги дээр үнэлгээ хийгээд үүнийг өөрчлөх шаардлага байна уу, цааш нь үргэлжлүүлээд явах

уу зэргийг эхний үнэлгээгээр гаргах юм. Энэ тал дээр та бүхний үнэлгээ чухал болно.

П.Болормаа: Төслийг дэмжиж байна, хөдөө орон нутагт уул уурхайн компаниас оруулсан хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх нь чухал байна. Орон нутагт ажиллахад иргэдийн хамгийн их асуудаг асуулт нь хичнээн ажлын байр сум орон нутагт бий болгов, орон нутгийн хөгжлийн гэрээ хийсэн үү, ямар төслүүд хэрэгжүүлсэн гэх мэт асуултыг ихэвчлэн сонирхдог. Манай компани орон нутагт тусгай төлөөлөгч, мэдээллийн төвийг ажиллуулдаг, сонин хэвлэлээр хийсэн ажил, хөрөнгө оруулалтын талаар байнга мэдээлэл өгсөөр байтал иргэд ямар ч мэдээлэлгүй байдаг. Манай компани Сэлэнгэ аймгийн Баянгол суманд ихээхэн хөрөнгө оруулалт хийсэн байхад иргэд нь мэдээгүй байсан, тухайлбал сумын төвийн барилга, түүнчлэн Улаанбаатар хотын нэгдүгээр төрөхийн өргөтгөлийн ажлыг хийж өгснийг бас мэдээгүй байсан. Иймээс уул уурхайн компаниудын хийж байгаа ажил, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Компани өөрсдийн хийсэн ажлын талаар мэдээлэл өгөхөөр орон нутагт үл ойлголцол үүсэх зэрэг хүндрэл гардаг тул гуравдагч этгээд үнэн зөв мэдээллийг өгөх нь чухал юм. Шалгуур үзүүлэлтийг дэмжиж байна. Тухайн сонгогдсон суманд үйл ажиллагаа явуулж байгаа компаниас төслийн хүрээнд тодорхой зарим ажлуудад туслах, дэмжлэг үзүүлэх боломжтой байгаа.

Л.Долгормаа: Орон нутгийн хүмүүсийн мэдээллийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх төсөл юм байна, Энэ төсөл чухал байна, бид хариуцлагатай уул уурхайн талаар сүүлийн жилүүдэд сумын түвшинд ажиллаж байна. Хөдөө орон нутагт ажилгүйдэл их байна, иймээс уул уурхайг зөвшөөрч байгаа. Яагаад гэвэл тэдэнд ажил хэрэгтэй, амьдрах хэрэгтэй байна, гагцхүү бие биенээ хэрэгтэй байна, юу хийгээд байгаагаа ойлгох хэрэгтэй. Уул уурхайтай сумыг сонгох, уул уурхайн талаар үнэн зөв мэдээллийг хүмүүст өгмөөр байна, сумын даргаас эхлээд багш нарт, банкны ажилтнуудад ойлголт өгөөд, тэднээс дамжуулан иргэд хүүхдүүдэд ойлголт өгөх хэрэгтэй байна.

Б.Болдбаатар: Монголчууд 20 гаруй жил гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна, үүнээс уул уурхайн салбарт амжилтанд хүрсэн төсөл би харсангүй. Иймд төслийн сайжруулах, амжилтанд хүрэх хэрэгтэй. ТАН эвсэлтэй хамтраад, тэдний санааг сонсоод ажиллах ёстой. Өнөөдрийн энэ төсөл ямар нэгэн зорилго, чиг үүрэг алга. Бид компаниудтай хамтарч ажиллах шаардлагатай, бид энэ төслийг хэрэгжүүлэх гэж байгаа бол ажлын хэсэг байгуулаад, сумаа сонгоод, орон нутагт очиж ажиллаад, мэдээллийг олон нийтэд хүргүүлж ёстой.

Н.Баярсайхан: Төслийг хэн санаачилсан бэ? Үйл ажиллагаагаа тогтоогүй, үнэлгээ хийгээгүй байж, яаж 12 сар гэдэг тоог гаргаж ирсэн бэ? Төслийн хүрээнд хаана, юу хийх талаар тохироогүй байж, хэрэгжүүлэгч байгууллагаа тогтоод, санхүүжүүлэгч хэдэн жилийн өмнө ярьж байсан төслийг одоо бариад, энэ хүрээнд юу хийхэв, хаана хийхэв гээд Ажлын хэсгийн хурал хийлгэж байгааг ойлгохгүй байна. Юу хийх гээд байгааг ойлгохгүй байна. ЕСБХБ хэд хэдэн уул уурхайн төсөлд санхүүжилт хийсэн байгаа түүнийгээ дагуулаад сумаа сонгоод явах сонирхол байна юм уу. Ер нь ЕСБХБ хэнд хаана ямар хэрэгцээ байгаа талаар ямар нэг тандалт хийгээд байна уу гэж санагдаж байна. 2014 онд ИНБ тай хэлэлцэж ямар хэрэгцээ байгааг судалсан бол одоо Ажлын хэсэгт нь ямар хэрэгцээ байна ямар чадавх байна гэж судлаад тандаад байна уу. Гэж хардаж эхэллээ.

П.Моффат: Ажлын албанаас анх төслийн санаа гаргасан, бид олон дахин ярилцаж, хэлэлцсэний үндсэн дээр уг төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ танилцуулгад хийгдэх ажлууд, зорилтуудыг тусгасан байгаа. Бид урьдчилаад бүх юмыг гаргаад бэлэн төсөл танилцуулвал болох байсан тэгсэн ч бас л шүүмжлүүлнэ. Өнөөдөр бид та бүхний саналыг авч байгаа, миний хувьд хийх ажил тусгагдсан гэж үзэж байгаа, судалгаа үнэлгээ хийх зэргийг үйл ажиллагаанд багтааж хийхээр оруулсан, сум сонголт дээр ч та бүхний санал, оролцоог хүсч байгаа.

Б.Баярсайхан: Ажлын алба санаачилсан юм бол, ажлын хэсэг байгуулаад ажлын алба нийлээд төслөө боловсруулах хэрэгтэй, төсөл санхүүжүүлэгч өөрөө төслөө боловсруулах нь буруу. Төсөл санаачилсан нь төслөө боловсруулаад, санхүүжүүлэгч нь санхүүжүүлээд явдаг зарчмаараа байя л даа. Яагаад санхүүжүүлэгч байгууллага өөрөө төслөө боловсруулаад, өөрөө хэрэгжүүлэгчээ сонгож ирээд хаана юу хийх үү, яах уу гээд байгаад үнэхээр ойлгохгүй байна. Иймд Ажлын хэсгийн хурлын шийдвэрт тусгах санал байна. Ажлын хэсгийн хүрээнд жижиг ажлын хэсэг байгуулаад, ажлын алба хамтраад төслөө боловсруулж, ажлын хэсгийн хуралд танилцуулах гэж оруулах саналтай байна. Ажлын хэсэг хэн нэгэн төсөл хэрэгжүүлэх гэсэн байгууллагын “хэрэгсэл” биш. Бид саналаа гаргасан бол төслийн хүрээгээ өөрсдөө гаргах ёстой.

Б.Батболд: Төслийн танилцуулга, юу хийх нь ойлгомжтой байна, дэмжээд хамтарч ажиллах хэрэгтэй. Туршилтын сум сонгоход нь саналаа өгцгөөе. Бид хамтарч ажиллаад сурсан, санаачилга иргэддээ хүрэхгүй байна гээд их ярьдаг байсан, одоо энэ төслийн сумыг баруун аймгуудаас ч юм уу сонгох хэрэгтэй байна. Би үүнийг том боломж байна гэж ойлгож байна, шууд сумаа сонгоод ажилдаа ормоор байна.

Н.Наранцэцэг: Төслийн талаар цахимаар санал авсан, хэдэн хүнээс ямар ямар санал ирснийг танилцуулна уу.

Ш.Цолмон: Ажлын хэсгийн гишүүдээс санал ирсэн. Тухайлбал, ТАН эвслийн Баярсайхан, БОАЖНХ-ын яамны ахлах мэргэжилтэн Б.Саран, Байгаль эхийн аврал сангийн тэргүүн Н.Наранцэцэг нэр санал өгсөн, гишүүд идэвхтэй оролцсон. Наранцэцэгийн хувьд Увс аймгийн Бөхмөрөн сумыг сонгох хүсэлт илэрхийлсэн, Баярсайханаас богино хугацаанд сонгох нь боломжтой юм уу, Б.Сарангаас сумын тоо цөөн байна гэх мэтээр саналууд ирсэн. Оролцогч талууд ихэнх нь энэ төслийг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа, нэмэлт ажлуудыг дараа нь хийх боломжтой байх.

Ч.Батцэнгэл: Тайлангийн зарим мэдээлэл дээр хамтарч ажиллах боломжтой. Бид тайлан гаргаагүй байгууллагад хариуцлага тооцдог, харин түүнийг олон нийтэд мэдээлэхгүй л байгаа.

Ш.Цолмон: Дараагийн долоо, 8 дугаар сарын 11-нд Монголын ОУИТБС-ын 2015 оны эхлэлтийн семинар зохион байгуулна, түүнд саналаа оруулж болно.

Н.Баттуяа: Сумын тоо арай цөөн байна, 10 сум байвал зүгээр байна. Мөн сонгох сумаа ашигт малтмалын төрлөөр нь ангилж, үзэж болох уу?

Н.Оюунцэцэг: Төслийг дэмжиж байна, сум сонгох шалгуурыг нарийсгах хэрэгтэй, тухайлбал төсөл хэрэгжиж буй эсэх гэдэг нь төсөл хэрэгжиж байгааг авах уу, үгүй

юу гэх мэт. Бид яамтай хамтраад төсөл хэрэгжих 5 сумыг сонгоход саналаа өгөх болно.

Д.Дуламсүрэн: Сумын тоо 5-аас илүү байх хэрэггүй байх, харин сумыг сонгох шалгуур үзүүлэлтээ эцэслэх хэрэгтэй, ойлгомжгүй юмнууд байна. Тухайлбал, уул уурхайтайг сонгох юм уу, ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжиж байсан сумыг сонгох уу гэх мэт эргэлзээтэй асуудлууд байна, бид өнөөдөр үүнийг шийдэж өгөөгүй болохоор дараагийн хурлаар бас л орж ирэх байх.

П.Моффат: Ажлын үүргийн удирдамж дээр төсөл өөрийн үйл ажиллагааны хувьд сонголтоо хийгээд явах боломжтой, үндсэн ажил хэвээрээ бага зэрэг өөрчлөлт орохоор харагдаж байна. Туршилтын төсөл учраас 5-аас илүү сум байх шаардлагагүй гэж үзэж байгаа.

П.Болормаа: Туршлага хуримтлуулах үүднээс 5 сум нь болох байхаа, дэндүү олон болвол чанаргүй болж магадгүй.

Б.Батболд: Төсөл хэрэгжүүлэгчээр ЕХБХБ дангаар байх уу, ажлын алба оролцох уу? Дотоодын зөвлөх компанийг ямар шалгуураар сонгох вэ? Ажлын хэсгээс баг гаргаад хамтраад ажиллавал яасан юм бэ гэсэн саналтай байна.

Ж.Пелл: Төсөл хэрэгжүүлэгч нь ЕХБХБ, үйлчлүүлэгч нь ажлын алба, ажлын хэсэгтэй хамтарч ажиллах зарчмаар явна. Эхлэлтийн тайлан, ажлын төлөвлөгөө боловсруулаад дараагийн хуралд танилцуулна. Үүний дараа зөвлөх компани сонгоно.

Ш.Цолмон: Бид ИНБ-уудтай хамтарч ажиллахыг санал болгосон боловч энэ нь нэг талдаа иргэний нийгмийн баримжаатай болчихоор дараа нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болох учраас харилцааны мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай гэсэн.

Л.Долгормаа: Батболдын саналыг дэмжиж байна, бүх аймаг сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга Тамгын газрын дарга гэх мэт бүх хүмүүсийг оролцуулсан семинар хиймээр байна.

Б.Батболд: Төр, ИНБ болон компанийг оролцуулаад хамтраад ажиллах боломжтой, бидэнд суманд ажиллаж байсан туршлага бий.

П.Моффат: ИНБ оролцох эрхтэй, гэхдээ бид 2 зүйл дээр тэнцлийг хангах хэрэгтэй байгаа. Харилцаа холбооны чиглэлийн ажлыг орон нутгийн төрийн байгууллагуудаар хийлгэх санал гаргаж байсан. Энэ нь мэдээллийн хараат бус байх зарчим алдагдах юм. Тэгэхээр бид аль болохоор иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулж ажиллах зохицуулалтыг нэмж оруулна. Энэ бүгдээс үзэхэд харилцааны холбооны мэргэжлийн байгууллага нь байдгаараа байгаад харин хаана нь ИНБ-ын оролцоог түлхүү оролцуулж болох вэ гэдэг дээр ажиллая.

Ш.Цолмон: Өнөөдрийн хурал үүгээр өндөрлөж байна, та бүхнийг хуралдаа ирж, идэвхтэй оролцсонд баярлалаа.

Шийдвэрлэсэн нь: Туршилтын төслийг дэмжиж, өнөөдрийн хуралдаанаас гарсан саналуудыг төсөлд нэгтгэж, дараагийн хуралдаанд танилцуулахыг ЕСБХАБ, Адам Смит байгууллагын төлөөлөлд зөвлөмж болгов.

Хурлын шийдвэрт Баярсайхан миний оруулсан санал тусгагдаагүй байх тул энэ саналыг шийдвэрт тусгахгүй гэсэн санал хураалт явуулсан уу, яагаад энэ талаар тусгаагүйг тайлбар оруулна уу

Хуралдаан 12,25 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
урлын тэмдэглэл хөтөлсөн:

Ш.Цолмон

Ажлын албаны санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг